



# KOENIG ба Энэтхэг

**С**ургалт гэдэг үгийг та залхтлаа сонссон байж магадгүй. Гэвч энэ талаар дахиад л ярихаас аргагүй нь.. Аливаа нэг ажлыг маш сайн чаддаг хүнтэй та таарч л байсан байх. Харахад хүртэл урамтай байдаг. Тэгвэл өндөр мэргэжлийн ур чадварыг сайн сургалтаар л олж авна. Хэдийгээр бие дааж сурч болох

боловч зайлшгүй сургалтаар олж авах мэдлэг гэж бас байна аа. Сайн сургалт нь хар практик дээр хэдэн арван жил болж байж мэдэх зүйлийг танд шууд хэлээд заагаад өгчихдөг тул маш их цаг хугацааг хэмнэж, богино хугацааны дотор таныг шилдэг мэргэжилтний төвшинд аваачиж дөнгөх юм.

**Б**и 2011 оны 5-р сарын 4-ээс 5-р сарын 8 хүртэл 5 хоногийн хугацаатай танилцах аялал хийгээд ирлээ. Энэ бол өөрсдийгөө "World's #1 Offshore Training" гэж цоллодог Энэтхэг улсын Дели хотноо төвтэй сургалтын төвтэй танилцах тухай юм.

ширтэх нүд, хэтэрхий давчуу гудамж, буруу талын хөдөлгөөн, хэлбэр муутай машинууд - энэ бүгд таны нүдэнд анхлан тусах болно. Энэ тал дээр бол манай Улаанбаатар хажууд нь хамаагүй цэвэрхэн, сайхан юм билээ. Гэхдээ л Делид 22 сая хүн тогтмол аж төрөн сууж байна. Ийм олуулаа болохоор тэнд баян хоосны ялгаа гаарсан гэхэд болно. Улаанбаатарт 1 сая хүн амьдардаг гэвэл 20 дахин нугалах бөгөөд тэнд сул үлдсэн 1 м/кв зай ч алга ажээ.

Aggarwal-ын хэлснээр бол тэдний амжилтын гол үндэс нь сайн багш нар бөгөөд тэднийг татах гол үндэс нь сайн нөхцөл юм байна. Анх 2002 онд жилд ганцхан оюутантай эхэлж байсан бол өнөөдөр сардаа 200-аас багагүй оюутан хүлээж авдаг. Сургагч багш нар 5-тай байсан бол өнөөдөр 140-ээс их болсон байна. Орлогын хувьд 7 сая доллараас багагүй болсон гэхээр хэр томорсон нь мэдэгдэж байгаа биз ээ.

Offshore гэдэг нь "Эргээс хол, далайн чанадад" гэсэн утгатай. Манай тохиолдолд харь улсад, хилийн чанадад, гадаадад гэсэн утгаар бууж хэрэглэгдэнэ. Өөрөөр хэлбэл зөвхөн гадаадын улсуудад зориулж сургалт явуулдаг гэсэн үг.

## KOENIG

**Х**эрвээ та Google дээр Cisco Training гэж хайвал Cisco.com-ын дараа www.koenig-solutions.com гэсэн вэб хуудасны линк байгааг харах болно. Энэ бол Энэтхэгийн Koenig сургалтын компанийн вэб хуудас юм. Google-д ийм дээгүүр эрэмбэлэгдсэн байгаа болохоор энэ талаараа дэлхийд муугүй үнэлэгдэж байгаа гэдэг нь ойлгомжтой юм.

2002 оноос эхэлсэн бизнес нь өнөөдөр дэлхийд дээгүүр үнэлэгдэх болсон нь Koenig-ийн зөв бодлоготой холбоотой юм. Koenig-ийг үндэслэгч Mr.Rohit

Бидний орсон сургалтын байр нь нилээд том бөгөөд жижигхэн жижигхэн өрөөнүүдтэй. Хананд тулгаж суурилуулсан ширээ, дажгүй тохилог дугуйтай сандал, Air Condition, самбар, компьютерууд.. Ингээд л болоо. Цонх байхгүй. Энэ өрөөнд багш та хоёр өдөржингөө ажиллах болно. Таны гол зорилго суралцах, юм мэдэж авах учраас саад болох зүйл нэг ч үгүй юм.

## АЯЛАЛ

**У**лаанбаатараас Бээжин хүртэл 1500 км, Бээжингээс Дели хүртэл 3800 км ниснэ. Нийт аяллын зай нэг талдаа 5300 км, замдаа бараг 1-2 өдөр болно. Дели нь өвөлдөө 20 градус зундаа 40 градус байдаг ерөнхийдөө халуун дулаан хот юм. Нийт жилийн дундаж температур нь 25-30 градус. Намайг очих үед 40 градусаас давж байсан тул арай л наранд нам цохиулчихсангүй. Koenig нь гадныханд Full Service (Бүрэн үйлчилгээ) үзүүлдэг тул хаа ч очсон Air Condition ажиллах ажээ.

Яг үнэндээ би Энэтхэгийг Хятадаас дутахгүй сайхан орон гэсэн төсөөлөлтэй байснаа нуугаад яхав. Гэвч хот руу орж явахдаа машины цонхоор харсан зүйлс гайхшруулсан гэхэд болсон. Хог новшин дунд унтаж байгаа гуйлгачин хүмүүс, хуучирч муудсан намхан байшин барилгууд, аймшгийн бүгчим халуун, эвгүй хурц үнэр, хүмүүсийнх нь цоо



## ТЭДНИЙ ДАВУУ ТАЛУУД

### Багш

Юуны өмнө маш сайн бэлтгэгдсэн багш нарыг дурдах хэрэгтэй. Монголд анагаах ухаанд сурц дуусдаггүй гэж ярилцдаг шүү дээ. Лав 8-10 жил өлхөн суралцдаг, яагаад гэвэл эмч нар хүний амь насыг хариуцдаг учраас сайн бэлтгэгдэхээс өөр аргагүй юм. Тэгвэл IT-ийн салбарт мөн ялгаагүй сайн суралцахгүй бол дорхноо хоцрогдоно. IT өөрөө жилээр биш сар өдрөөр үсрэнгүй хөгжиж байгаа. Иймээс тэдний багш нар энэ тал дээр онцгой анхаарч, өөрсдийгөө хөгжүүлэх тал дээр бүхнийг хийдэг.

## 1 харьцах 1

Koenig нь 2010 оны Сургалтын салбарын ажиллахад хамгийн таатай орчин бүрдүүлсэн шилдэг компаниар шалгарсан байна.

1 харьцах 1 гэдэг ойлголт нь Koenig-ийг өнөөгийн шилдэг сургалтын компани болгоход гол нөлөөлсөн хүчин зүйл юм. Өөрөөр хэлбэл 1 сурлагчид 1 багш гэсэн утгатай. Тэгэхээр тухайн суралцагч болгонд таарсан тусгай хөтөлбөр, аргаар ажиллах боломжтой.

Ялангуяа бага биш мөнгө төлж хилийн дээс алхаж, урт зам туулж байгаа суралцагчдад энэ бол байх ёстой хүндлэл билээ. Мэдээж яаж ч бодсон өндөр зэрэглэлийн багш тантай яг тулж ажиллана гэдэг бол үнэхээр том хүндлэл бөгөөд дараах давуу талуудыг баталгаатай олгоно.

1. Багшийн анхаарал өөр суралцагч руу хуваагдахгүй зөвхөн танд хамааралтай тул таны ойлгох, суралцах хугацаа эрс багасна.
2. Маш чанартай сургалт явагдана. Сурлагч багш ширхэг болгоныг тайлбарлах таны ойлгоогүй өгүүлбэр бүрийг тайлбарлах болно.
3. Таны хувийн онцлогоос шалтгаалан сургалт бүрэн хэмжээнд давтагдахгүй байдлаар явагдана.
4. Анги дүүргэхийг хүлээх шаардлагагүй, дуртай өдрөөсөө сургалтаа эхэлнэ.

## Хэрвээ та эсвэл танай байгууллага шилдэг ажилтнаа Koenig-т сургахыг хүсэж байгаа бол дараах зөвлөмжүүдийг уншина уу.

- Өөрийнхөө үр чадварт таарсан track-ийг сонгоно уу. Үүний тулд Koenig-ийн сайт руу орж Knowledge Level Test бөглөж болох юм.
- Аль болох эртхэн захиалгаа өгвөл тун сайн. Дор хаяж 15-20 өдрийн өмнөөс харилцаж төлөвлөвөл зүгээр байдаг.
- Суралцах ажиллагаа нилээд хүнд байдалд явагдана. Иймээс сэтгэл санааны болоод биеийн бэлтгэлтэй байх хэрэгтэй. 1 харьцах 1 байдлаар явагдаж байхад суралцагч өдөрт дор хаяж 10-12 цаг ажиллах шаардлагатай.
- Хэрвээ та notebook буюу зөөврийн компьютертай бол түүнтэйгээ ирвэл тун сайн. Ингэснээр та

үдшийн цагаар гэр бүлтэйгээ холбогдох, маргаашийн хичээлдээ бэлтгэх, туршилт явуулах боломжтой болно. Хэрвээ танд notebook байхгүй бол Koenig-аас өдрийн \$7 долларар түрээсэлж болох юм байна.

- Буцах билетээ сургалт дуусахаас хэдэн өдрийн өмнө захиалах хэрэгтэй. Ингэснээр билетгүй болж өдөр алдах аюулгүй болно.
- Koenig нь 24x7 байдлаар онгоцны буудал хүртэл үйлчилдэг.
- Хэрвээ та илүү өндөр зэрэглэлд үйлчилгээ хүсэж байвал Koenig-т Corporate Pack бий. Та илүү мөнгө төлөөд илүү тансаг үйлчилгээ авна гэсэн үг.
- Хэрвээ танд эрүүл мэндийн асуудал байдаг бол бидэнд урьдчилан мэдэгдэх хэрэгтэй. Ерөнхийдөө энэтхэгийн эмч мэргэжилтнүүд нь дэлхийн дээгүүрт үнэлэгдэх чадвартай гэдэгт эргэлзэх хэрэггүй. Түүнчлэн суралцагсдаа шүд, нүд, ходоод гэдэс гэх мэт олон



өвчний үед найдвартай тусламж үзүүлж байсан.

- Энэтхэгт ирэхээсээ өмнө та боломжийн хирээр энэтхэгийн тухай мэдээлэл олж авбал сайн шүү.
- Энэтхэг хоол нь ерөнхийдөө халуун ногоотой. Түүнчлэн халуун орон учир мах багатай байдаг. Гэвч Koenig-т барууны оюутнууд ихээр сурдаг тул гахай, тахианы махыг өргөн хэрэглэдэг.

## Мөнгөө хэмнэж болох дараах зөвлөгөөнүүдийг Koenig өгч байна.

- Хэрвээ та хэд хэдэн үр чадвар эзэмшиж сурахыг хүсэж байвал нэг дор хэд хэдэн сертификат авч болох юм. Ингэснээр та хэд хэдэн курсийг нийтэд авах мөнгөө үлэмж хэмжээгээр багасгана.
- Онгоцны билет захиалахдаа туршлагатай хүмүүсээс зөвлөгөө аварай. Онгоцны билетээс ихээхэн мөнгө хэмнэж болдог.
- Хэрвээ та бүхэн 2-оос олуулаа ирвэл Энэтхэгийн хотоор аялах зардлуудыг нилээд бууруулна гэсэн үг.
- Энэтхэгт компьютерийн номууд маш хямдхан байдаг. Иймээс та ном худалдаж авах төлөвлөгөөтэй бол энэ нь тун сайн хэрэгжих боломжтой.

Манай орноос тэнд суралцаж төгссөн хэд хэдэн хүмүүс байдаг бөгөөд бүгд сэтгэл хангалуун байгаа. Манай орны томоохон аж ахуйн нэгжүүд, байгууллагууд хүмүүсээ сургах нь зүйтэй болов уу.

Хэрвээ та энэтхэгийн Koenig компанид IT-ийн өндөр зэрэглэлийн сургалтад сууж өндөр чадвартай болж шилдэг мэргэжилтэн болохыг хүсэж байвал <http://www.koenig-solutions.com> сайт руу орж тэдэнтэй шууд холбогдож болно.



Эсвэл Компьютер Таймс сэтгүүлийн газарт хандаж болно. Бид танд ямар ч нэмэлт төлбөргүйгээр бүхий л шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг өгөх болно.

Утас: 99902070 /Жаргал/

## Keonig компаниас явуулдаг сургалтуудаас...

Сургалтын төрөл, ангилал	Энгийн		Түргэвчилсэн		Маш түргэвчилсэн	
	Хугацаа ба үнэ	Өдөр	Үнэ /USD/	Өдөр	Үнэ /USD/	Өдөр
<b>Microsoft</b>						
MCITP: Enterprise Administrator – Windows Server 2008	35	4,930	21	3,420	16	3,920
MCITP: Enterprise Desktop Administrator Windows 7	11	1,210	-	-	7	1,250
MCITP: Enterprise Desktop Support Technician 7	11	1,220	-	-	7	960
Microsoft Project 2010	4	680	-	-	-	-
MCITP: Server Administrator – Windows Server 2008	20	2,990	12	2,080	9	2,240
MCITP: Enterprise Administrator & Enterprise Messaging Administrator	54	7,810	40	6,300	27	6,410
Upgrade from MCSE 2003 to MCITP: Enterprise Administrator	18	2,510	12	1,820	9	1,820
Working with Data in T-SQL for the Non Database Administrator	4	480	-	-	-	-
Understanding and Querying Relational Data for Information Workers	3	340	-	-	-	-
SQL Server 2008 Policy Based Management	4	660	-	-	-	-
SQL Server 2008 Failover Clustering	4	660	-	-	-	-
Upgrade from MCSE 2003 to MCITP: Server Administrator	15	2,000	11	1,570	7	1,490
MCITP: Microsoft Lync Server 2010, Administrator	13	2,700	9	1,810	6	1,780
MCITP SQL Server 2008: Database Developer and Database Administrator	34	4,510	24	3,270	16	3,050
<b>SQL Server</b>						
MCTS: Microsoft SQL Server 2008, Implementation and Maintenance	7	950	5	680	4	720
MCTS: Microsoft SQL Server 2008, Database Development	11	1,410	7	990	5	940
MCTS: Microsoft SQL Server 2008, BI Development and Maintenance	12	1,640	9	1,230	5	1,060
Updating Your SQL Server 2005 Skills to SQL Server 2008	4	540	-	-	-	-
Microsoft SQL Server 2008 for Experienced Oracle Database Administrator	5	610	-	-	-	-
Developing Spatial Data Solutions With Microsoft SQL Server 2008	3	470	-	-	-	-
Upgrading SQL Server 2000 Database Administration (DBA) Skills to SQL Server 2008 DBA	4	480	-	-	-	-
Career Enabler: Microsoft Database Developer	66	7,030	44	4,890	-	-
Career Enabler: Microsoft Database Administrator	66	7,030	41	4,700	-	-
MCITP: Database Developer	25	2,800	17	2,020	12	1,960
MCITP: Database Developer: SQL Server 2008	17	2,230	11	1,530	7	1,450
<b>.NET</b>						
MCPD: Enterprise Application Developer 3.5	37	4,580	26	3,490	18	3,340
MCPD: ASP.Net Developer 3.5	18	2,190	13	1,700	10	1,720
MCPD: Windows Developer 3.5	27	3,290	19	2,450	13	2,350
MCPD Web Developer 4	33	4,200	22	3,000	15	3,080
MCPD Windows Developer 4	28	3,570	19	2,690	14	2,860
MCTS: .NET Framework 3.5, ADO.NET Applications	11	1,390	-	-	6	1,100
MCTS: .NET Framework 3.5, Windows Presentation Foundation Applications	12	1,490	9	1,240	6	1,100
MCTS: .NET Framework 3.5, Windows Communication Foundation Applications	12	1,490	9	1,240	6	1,200
MCTS: Windows Application Development with .NET 4.0	13	1,500	-	-	6	1,060
<b>Microsoft Dynamics CRM</b>						
MSCBMSS - Applications in Microsoft Dynamics CRM 4.0	5	720	-	-	-	-
MSCBMSS - Customization and Configuration in Microsoft Dynamics CRM 4.0	5	720	-	-	-	-
MSCBMSS - Installation and Deployment in Microsoft Dynamics CRM 4.0	4	570	-	-	-	-
MSCBMSP - Applications for Microsoft Dynamics CRM 4.0	21	2,600	-	-	-	-
<b>SharePoint</b>						
MCTS: SharePoint Server 2007, Configuration	14	2,280	-	-	7	1,610
Microsoft Office SharePoint Designer 2007	4	680	-	-	-	-
SharePoint Designer 2010	3	410	-	-	-	-
MCTS: MS Office SharePoint Server 2007-Application Development	9	1,340	-	-	-	-
Implementing Forefront Unified Access Gateway 2010	5	850	-	-	3	570
Microsoft SharePoint 2010, Application Development	7	1,130	-	-	5	1,020
<b>Cisco</b>						
SMN - Implementing Security Manager for Cisco Networks v1.1	5	1,610	-	-	3	1,220
CCNA Security and CCNP Security	39	7,870	26	6,180	19	6,040
Cisco VPN Security Specialist	16	3,280	11	2,480	-	-
Cisco Firewall Security Specialist	16	3,280	11	2,480	-	-
CCNA, CCNP, CCNA Voice v8.0 & CCNP Voice v8.0	68	15,540	53	13,470	-	-
<b>Linux / Unix</b>						
RHCT	20	2,570	12	1,630	8	1,560
RHCE	30	3,820	17	2,400	12	2,570
RHCE (2 takes)	33	4,580	20	3,150	15	3,320
Red Hat Certified Security Specialist (RHCSS)	25	4,110	18	3,010	13	3,070
RHCA	40	10,190	-	-	-	-
Novell Certified Linux Administrator (CLA) 10	16	1,630	11	1,220	7	1,090
<b>Red Hat</b>						
Red Hat Certified System Administrator (RHCSA)	20	2,570	12	1,630	8	1,560
Red Hat Certified Virtualization Administrator	9	-	-	-	5	-
Red Hat Apache and Secure Web Server Administration	7	920	5	610	3	470

<b>Java Technology</b>						
Java – Basic Level	18	1,910	12	1,630	8	1,560
Java - Intermediate Level	18	2,300	12	1,860	6	1,270
Java – Advance Level	20	2,610	13	1,760	-	-
OCA, Java SE 5/SE 6 (formerly SCJA)	9	950	6	690	4	710
OCP, Java SE 6 Programmer (formerly SCJP)	13	1,310	9	950	6	1,040
OCP, Java EE 5 Web Component Developer (formerly SCWCD)	13	1,480	11	1,270	9	1,350
OCP, Java EE 5 Business Component Developer (formerly SCBCD)	13	1,480	11	1,270	9	1,350
Java EE 6	12	1,290	7	780	-	-
<b>Oracle</b>						
Oracle Certified Associate (OCA) DBA 11g	14	3,330	10	2,710	7	2,690
Oracle Certified Professional (OCP) DBA 11g	21	5,020	17	4,400	12	4,340
Oracle 11g: PL/SQL Developer OCA	11	2,520	-	-	7	2,410
Oracle 11g: Advance PL/SQL Developer OCP	16	3,640	-	-	10	3,370
Oracle Database 11g: Performance Tuning	7	1,730	-	-	5	1,660
Oracle Database 11g: Data Warehousing Fundamentals	5	1,210	-	-	-	-
<b>Adobe</b>						
Adobe Dreamweaver CS4	9	1,120	6	880	4	790
Adobe Dreamweaver CS5	9	1,130	6	890	4	790
Adobe Flash CS5	9	1,130	6	890	4	790
Adobe Flex 4	9	1,130	6	890	4	790
Career Enabler – Web Designing	32	4,350	-	-	-	-
<b>English</b>						
English Course	10	1,370	-	-	-	-
<b>Security</b>						
Configuring Juniper Networks Firewall / IPSEC VPN Products (CJFV)	5	1,150	4	950	3	870

Энд байгаа зардалд:

- Энэтхэгт буусан өдрөөс эхлээд явах хүртэл гарах зардлууд буюу өглөө, өдөр, оройн хоол, байр, сургалтын төв рүү явах тээвэр зэрэг бүх зардлууд багтана.

**Т**иймээс үүн дээр нэмэгдээд онгоцны билетийн үнэ орно. УБ-т байгаа монголчуудын хувьд УБ-Бээжин-Дели гэсэн маршрутаар явна. Air china авиа компанийн онгоцуудаар нислээ гэхэд очих буцахтайгаа нийлээд 1 сая 300 мянга орчим төгрөг болдог. Та зардлаа хэмнэж Бээжин рүү галт тэргээр явж болох юм.

Түүнчлэн хэрвээ та тэндээс нөүтбүүк, гар утас худалдан авах, аялах зэрэгт зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг ажээ.